



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 592

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 467 дугаар тогтоолын 2.1 дэх тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 7 нэрийн, нийт 377,172,993.23 (гурван зуун далан долоон сая нэг зуун далан хоёр мянга есөн зуун ерэн гурван төгрөг хорин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 338,492,383.99 (гурван зуун гучин найман сая дөрвөн зуун ерэн хоёр мянга гурван зуун наян гурван төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Мөнгөнхөлөгт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002634
27-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн
... дугаар тогтооллын хавсралт

"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	УАЗ пургон маркийн, 19-09 БРА улсын дугаар, 374100E0440690 арлын дугаар	2014.09.30	ш	1	47,927,668.92	47,927,668.92	37,755,406.01	10,172,262.91	10,200,000.00
2	Авто кран маркийн, тусгай зориулалтын, 04-87 ДГС улсын дугаар, LGHXBD1H096608601 арлын дугаар	2010.06.30	ш	1	73,831,079.54	73,831,079.54	73,831,079.54	-	30,000,000.00
3	Авто кран маркийн, 97-17 ХЭА улсын дугаар, LGHXCD1M2BN068687 арлын дугаар, тусгай зориулалтын	2011.12.31	ш	1	110,811,553.58	110,811,553.58	82,303,207.25	28,508,346.33	30,000,000.00
4	Тоёота ландкрузер-100 маркийн, 56-05 УНА улсын дугаар, JTEHT05J812016699 арлын дугаар, суудлын	2001.01.01	ш	1	59,816,745.40	59,816,745.40	59,816,745.40	-	10,000,000.00
5	УАЗ-22069 фургон маркийн, 02-59 ДГА улсын дугаар, ХТТ2206A0426709 арлын дугаар	2010.12.31	ш	1	18,600,000.00	18,600,000.00	18,600,000.00	-	2,000,000.00

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
6	Пик-Ап Риск-ур маркийн, 47-99 БРА улсын дугаар, LGWDB3170CC658226 арлын дугаар, суудлын	2012.08.31	ш	1	39,889,945.79	39,889,945.79	39,889,945.79	-	2,500,000.00
7	УАЗ -22069 фургон маркийн, 55-64 ДУА улсын дугаар, ХТТ2206А0426682 арлын дугаар	2010.11.30	ш	1	26,296,000.00	26,296,000.00	26,296,000.00	-	2,000,000.00
Нийт дүн						377,172,993.23	338,492,383.99	38,680,609.24	86,700,000.00
						(гурван зуун далан долоон сая нэг зуун далан хоёр мянга есөн зуун ерэн гурван төгрөг хорин гурван мөнгө)	(гурван зуун гучин найман сая дөрвөн зуун ерэн хоёр мянга зургаан зуун есөн гурван наян гурван төгрөг ерэн есөн мөнгө)	(гучин найман сая зургаан зуун наян мянга зургаан зуун есөн төгрөг хорин дөрвөн мөнгө)	(наян зургаан сая долоон зуун-мянга)